



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН
ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2020 оны 10 сарын 26 өдөр

Дугаар 30

Улаанбаатар хот

XXX ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

Улсын онцгой комиссын XXX дүгээр хурал 2020 оны 10 дугаар сарын 26-ны өдрийн 14:00 цагт Төрийн ордон дахь Шадар Сайдын ажлын өрөөнд 96.8 хувийн ирцтэй хуралдав.

Хурлыг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга Я.Содбаатар даргалж, холбогдох үүрэг даалгаврыг өгөв.

ХЭЛЭЛЦСЭН НЬ:

1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлын нөхцөл байдлын талаарх мэдээлэл

Эрүүл мэндийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн
Т.Мөнхсайхан

2. Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлсэн хугацааг сунгах тухай

Улсын онцгой комиссын орлогч дарга,
Онцгой байдлын өрөнхий газрын дарга,
Бригадын генерал Г.Ариунбуян

3. Улс хоорондын болон дамжин өнгөрөх ачаа тээврийн зохицуулалтын талаар

Зам тээврийн хөгжлийн сайд,
Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар

4. Бусад

ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Засгийн газрын Хэрэг эрхлах газрын Тэргүүн дэд дарга,

Улсын онцгой комиссын гишүүн Б.Ганбат,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч
дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн,
Бригадын генерал Ж.Бямбасурэн,

1.1. Коронавируст халдварт (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, эрсдэлийг бууруулах зорилгоор улсын хэмжээнд тогтоосон гамшигийн хамгаалах индеркуулсан бэлэн байдлын зэрэгт хэсэгчилэн шилжүүлсэн хугацааг 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрийг дуустал хугацаагвар сунгах асуудлыг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцэн шийдвэрлүүлэхээр тогтвортойт.

Хоёр. Зам тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссын гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн М.Менхсайхан,
Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Н.Анхбаяр,
Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч
дарга, бригадын генерал Г.Ариунбуян,

Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн,
Бригадын генерал Ж.Бямбасурэн,

Цагдаагийн ерөнхий газрын дарга, Дотоодын цэргийн командлагч,

Улсын онцгой комиссын гишүүн, цагдаагийн хурандав Ж.Болд,
Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын
гишүүн Т.Гантула,

Монгол-Оросын хувь нийлүүлсэн нийгэмлэг Улаанбаатар төмөр замын
дарга Д.Жижиднямаа,

Аймаг, нийслэлийн Засаг дарга нарт:

2.1. Сэлэнгэ аймаг дахь хилийн Алтанбулаг боомтоор импортын болон дамжин өнгөрөх ачаа тээвэрлэлт гүйцэтгэж байгаа жолооч нарыг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн нутгийн гүнд зорчуулахгүй байх зохион байгуулалтын арга хэмжээг авах, холбогдох байгууллагуудын төлөөллийг оролцуулсан ажлын хэсгийг томилон ажиллуулж, шаардлагатай тооцоо судалгаа, санал, дүгнэлтийг гаргаж 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор танилцуулах;

2.2. Сэлэнгэ аймаг дахь хилийн Алтанбулаг боомтод улс хоорондын тээвэрлагчдийг халдвартын эрсдэлээс хамгаалах тусгаарлалтын бүсийг 2020 оны 12 дугаар сарын 01-ний өдрийн дотор байгуулах,

2.3. Баян-Өлгий аймаг дахь хилийн Цагааннуур, Увс аймаг дахь хилийн Боршоо боомтын ажиллах хуваарийг гарагийн хуваарьт шилжүүлэх, халдварт хамгаалалтын дэглэмийг чанд мөрдүүлэх, PCR шинжилгээ хийх явуулын лабораторийг байгуулж, үйл ажиллагааг жигдүүлэх;

2.4. ОХУ-ас ирж байгаа олон улсын ачаа тээврийн жолооч нараас халдварын эрдэл нэмэгдэж байгаатай холбогдуулан хилийн Алтанбулаг, Цагааннуур, Боршоо боомтоор зорчин ирж буй жолоочийг коронавируст халдварт /Ковид-19/-ын PCR-шинжилгээг /72 цагийн дотор хийлгэсэн байх/ үндэслэн улсын хилээр нэвтрүүлах;

2.5. Тээврийн хэрэгслийн зутгуур болон жолооч нарыг солих тохиолдолд ОУ-ын ачаа тээврийн жолооч нарыг халдварын эрдэлээс хамгаалах "тур тусгаарлах байр"-ыг бэлтгэх, ачигчдын багийг бурдуулзах ажлыг Сэлэнгэйн Онцгой Комисс, Чөлөөт бусийн захиргаа хамтран зохион байгуулах;

2.6. Сүхбаатар-Наушки, Замын-Үүд-Эрээн төмөр замын боомтоор тээвэрлэж байгаа ачаа, вагон хүлээнцэгч агент, машинист /төмөр замын хөлөг ажилтан/-ын хөдөлгөөнд тавих хяналтын тогтолцоог сайжруулах, коронавируст халдварт /Ковид-19/-ын PCR шинжилгээнд хамруулж байх;

2.7. Монгол Улс, БНХАУ хооронд олон улсын ачаа тээвэрлэж буй монгол жолооч нарыг коронавируст халдварт /Ковид-19/-ын эрдэлээс хамгаалж байгаа тусгаарлалтын нехцэл байдлыг үнэлж, тодорхойлох ажлыг Гадаад харилцааны яам, Эрээн хот дахь Консулын газрын шугамаар зохион байгуулах;

Гурав.

Зам тээврийн хөгжлийн сайд,

Улсын онцгой комиссийн гишүүн Л.Халтар,

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссийн гишүүн М.Менхсайхан,

Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссийн орлогч дарга, бригадын генерал Г.Ариунбаян,


Хил хамгаалах ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссийн гишүүн, бригадын генерал Ж.Бямбасурэн,

Мэргэжлийн хяналтын ерөнхий газрын дарга,

Улсын онцгой комиссийн гишүүн Т.Гантулга,

Улсын онцгой комиссийн Шуурхай штабт;

3.1. "Хилийн авто замын боомтоор улс хоорондын ачаа тээвэрлэлтийг зохион байгуулах түр журам", "Онцгой нехцэлд улс хооронд дамижуулан өнгөрүүлэх ТИР карней бүхий бараа, тээврийн хэрэгсэлд хяналт тавих түр журам"-ыг 2020 оны 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор шинчлэн боловсруулж батлуулах;

МОНГОЛ УЛСЫН ШАДАР САЙД
УЛСЫН ОНЦГОЙ КОМИССИЙН ДАРГА   Я СОДБААТАР

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССИЙН НАРИИН БИЧГИЙН ДАРГА,
ДЭД ХУРАНДАА  Т.МОНХДОРЖ